



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/265

Алтай хот

**Монгол туургатан залуучуудын чуулга
уулзалт зохион байгуулах ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "Монгол туургатан залуучуудын чуулга уулзалт" арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Чинбат	(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Ш.Эрдэнэбат	(аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	С.Мөнхжаргал	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Д.Төмөрбаатар	(Цэргийн штабын дарга)
	Т.Сүхбаатар	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Алтайбаатар	(Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)
	С.Цагаанбаатар	(Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)


2.

Ж.Амгаланбаатар (Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Т.Эрхэмбаяр (Инноваци, судалгаа, бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирал)
Н.Мэндбаяр (Цагдаагийн газрын дарга)
Ж.Уранчимэг (Биеийн тамир спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Г.Болдбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Алтанзагас (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын дарга)
Э.Отгонбаатар (Ардын дуу бүжгийн Алтай чуулгын дарга)
Х.Ундармаа (Насан туршийн боловсролын төвийн захирал)
И.Гантулга ("Нийтлэг үйлчилгээ" УТҮГ-ын дарга)
Нарийн бичгийн дарга:Т.Баярзул (Сумын Засаг дарга нар) (Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухааны бодлого хариуцсан мэргэжилтэн)

2.Ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө гарган батлуулж, үр дүнтэй удирдан зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Г.Чинбат)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР